



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/105

Дэлгэрхаан сум

Ногоон зурвас байгуулахад хөрөнгө
зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6 дахь заалт, 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 63 дугаар зарлиг, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 13-ны 19 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлага “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд сумын төвд ногоон зурвас байгуулах ажлыг зохион байгуулж хөрөнгө зарцуулсугай.

3. Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хүрээнд төлөвлсөн ногоон зурвас байгуулахад ажилд шаардагдах 4,000,000 (дөрөв сая) төгрөгийн зардлыг амьдрах чадвар сайтай хөрсөнд тохирсон тарьц суулгацыг авч, суурин газарт ногоон байгууламж байгуулах зураглалтай уялдуулж бий болгож ажиллахыг байгаль хамгаалагч (Х.Мөнхбат)-д, хяналт тавьж ажиллахыг байгаль орчны хяналтын улсын байцаагч (У.Ариунтуяа)-д үүрэг болгосугай.

4. Дээрх ажилд шаардагдах хөрөнгийг тарьц суулгац нийлүүлсэн байгууллагын дансанд шилжүүлэхийг Засагт даргын Тамгын газрын нягтлан (О.Анхцэцэг)-т, Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Д.Батнасан) нарт даалгасугай.

ДАРГА  Б.ЭНХ-АМГАЛАН

2325010332



Soln

۲۵۵۵ ۲۵ ۲۷

متر و متر لنگر بقص

[illegible][illegible][illegible][illegible]